

## ЭВЭР ШҮТЛЭГ

### Б. ЦОГЗОЛМАА

Улаанбаатарын Их Сургууль, Археологийн тэнхим  
e-mail: tsogzolmaa99@gmail.com

**Түлхүүр үг:** Эвэр, эвэр шүтлэгтэй холбоотой зан үйл, эвэр шүтлэгт ард түмэн, эвэрт дуулга

**Өгүүллийн товч агуулга:** Энэхүү өгүүлэлд эртний судлалын дурсгалаас цөөнгүй тоогоор илэрч буй амьтдын эврийн олдвор дээр үндэслэн эвэрт амьтдыг шүтэх үзэл, эвэр шүтлэгтэй холбоотой асуудлыг сөхөн тавьж байна. Ийнхүү судлахдаа түүхэн мэдээ баримтыг харьцуулан нэгтгэн дүгнэх аргыг хэрэглэлээ.

Оршуулгын зан үйл нь тодорхой нэгэн цаг үед амьдарч байсан хүмүүсийн сүсэг бишрэл, хойд насны тухай ойлголтыг илэрхийлдэг чухал баримт болж өгдөг. Тиймээс булшны малталтын үеүдээс гарч буй эд өлгийн зүйлс нь ямар нэг мэдээллийг агуулж байдаг.

Судалгааны эх хэрэглэгдэхүүнээс шүүж үзвэл хүрлийн сүүл, төмрийн эхэн үеийн дурсгал болох Казахстаны Алтайд малтан судалсан Берелийн соёлын 11-р булшинд арван гурван адууг хүнтэй нь хамт хойлголон оршуулсан байна. Адуу тус бүрийг иж бүрнээр гоёл чимэглэл зүүлгэн эмээллэснээс гадна дөрвөн адууг янгирын эвэр бүхий маск зүүлгэсэн (Горбунов, Самашев, Северский, 2005: 102) байна (Зураг 1, 2, 3, 4).



**Зураг 1.** Берелийн 11-р булшны дотоод зохион байгуулалтыг сэргээн засварласан байдал (Горбунов, Самашев, Северский, 2005)



**Зураг 2.** Берелийн 11-р булшны эвэртэй маск зүүсэн адууг сэргээн засварласан байдал (D, Проф Д.Баярын хувийн фондоос авав).

Мөн Хүннүгийн үеийн булшнаас бугын эвэр ихээр гарч байна. Тухайлбал: Архангай аймгийн Батцэнгэл сумын нутаг дахь Худгийн толгойд малтан судалсан 1-р булшны нүхний төв хэсгээс бугын эврийн салаа гарсан (Юнь Хёнвонь, 2003: 122). Тус аймгийн Хайрхан сумын нутаг Гол модны 21С булшны баруун хэсэгт нарийн үзүүрийг нь хөрөөдөж тэгшлэн зассан бугын эврийн нэг салааг баруун хойш

хандуулан (Ёрөөл-Эрдэнэ, 2004: 78) тавьсан байна. Мөн Гол модны оршуулгын газраас домгийн амьтан болох ганц эвэртийг дүрсэлсэн чимэглэл (Ёрөөл-Эрдэнэ, 2007: 17) олдсон (Зураг 5).



**Зураг 3.** Берелийн 11-р булшны адууг сэргээн засварласан байдал (Проф Д.Баярын хувийн фондоос авав).



**Зураг 4.** Берелийн 11-р булшны адууны маскны янгирын эвэр (Горбунов, Самашев, Северский, 2005)



**Зураг 5.** Хүннүгийн үеийн булшнаас гарсан ганц эвэртэнг дүрсэлсэн чимэглэл (Ёрөөл-Эрдэнэ, 2007).


Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Бурхан толгойн 11-р булшнаас 30 см урт бугын эвэр мөн нэг богино салаа гарчээ. Бурхан толгойн 15-р булш нь модон хашлагатай эрэгтэй хүнийг оршуулсан ба эндээс буга, гөрөөсний эврээр хийсэн ямар нэгэн зүйлийн бариул бололтой зүйл мөн тахилын хайрцагнаас бугын эврийн хэсэг илэрсэн (Төрбат, Амартүвшин, Эрдэнэбат, 2003: 59,60). Бурхан толгойн 17-р булшны нүхний зүүн хойд булангаас бугын эвэр гарсан ба булшинд хорин таваас дээш насны эрэгтэй хүнийг оршуулжээ (Төрбат, Амартүвшин, Эрдэнэбат, 2003: 50). Бурхан толгойн 18-р булшны дараасыг хуулах явцад чулуун өрлөгийн баруун урдаас бугын эврийн хэсэг гарсан, булшинд гучаас дээш насны эрэгтэй хүнийг оршуулжээ (Төрбат, Амартүвшин, Эрдэнэбат, 2003: 51). Бурхан толгойн 65-р булшнаас бугын эврийн хэсэг олдсон, эл булшинд эрэгтэй хүнийг оршуулсан байна (Төрбат, Амартүвшин, Эрдэнэбат, 2003: 83).

Архангай аймгийн Хайрхан сумын нутаг Наймаа толгойн 5-р булшнаас буган чулуун хөшөөний дээд үзүүрийн хугархай болох дээрээ 15 см голчтой 30 цацраг бүхий нарны дүрс зэргийг урласан чулуу, бугын эврээр хийсэн үзүүртээ сэнжтэй 50 см урт эдлэл олдсон (Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал, 1999: 152).

Тус аймгийн Тамирын Улаан хошууны 17-р булшнаас зарим салааг нь тайрч засан, эврийн угийг нь хажуугаас нь засаж нүхэлсэн 60 см урт бугын эвэр гарсан бөгөөд хашлагын толгой талд тусгайлан хийсэн тасалгаанд хүндэтгэлтэйгээр тавьсан (Баруун Монгол, 2006: 4) зэрэг олон жишээг зурдаж болно. Мөн бугын

эврээр хийсэн зүүлт, цагираг, зуузайтай төмөр амгай зэрэг олдворууд цөөнгүй булшнаас гардаг.

Монголчуудын дунд ганц мод, гаж хэлбэр дүрс бүхий хад чулуу болон өөрсдийн овог аймгийн шүтээн болох ан амьтан зэргийг эртнээс сүсэглэн биширсээр ирсэн уламжлал бий. Тотем амьтан болох бугын бусад туурайтан амьтдаас ялгагдах онцлог бол түүний сүрлэг сайхан эвэр, гоо үзэмж бүхий бие цогцост оршино. Төв Азийн нутагт өргөн тархсан бугыг Евразийн тал хээрийн ихэнх нүүдэлчид, мөн тодорхой хэмжээгээр Ойрхи Дорнодын ард түмнүүд шүтэн биширч байсан (Анхбаяр, 2005: 10). Тухайлбал, бугыг намнах бол түүнд гурван удаа мөргөдөг. Тэгээд эврийн адгийн хараанаас адис авч толгойг нь модонд өлгөж үлдээдэг байжээ (Монгол ёс заншлын бага тайлбар толь, 1990: 19). Тотем амьтан нь овог аймгийн гишүүдийг ил, далдаар ивээн харгалздаг бөгөөд түүнийг ямар нэгэн хэлбэрээр гомдоовол гай зовлон авчирна гэж үздэг (Монголын уламжлалт цээр ёсон, 1997: 52) ойлголт алтай хэлт ард түмний дунд түгээмэл байдаг. Монгол орны хадны зурагт эвэрт амьтад болох буга, янгир зэрэг амьтдыг дүрслэснээс гадна эвэр шүтлэгийн хэлбэр цөөнгүй тохиолддог. Жишээлбэл: Алтай нурууны ноён оргил Алтай Таван Богдын зүүн сугаас эх авч урсах Цагаан Салаа, Бага Ойгарын голын хөндийд арван мянга гаруй хадны зураг байгаагийн нэгд толгойн хоёр талд нь эвэр бүхий морьтой хүнийг дүрсэлжээ (Зураг 6). Мөн тус дурсгалт газрын морьтонгуудыг дүрсэлсэн нэг зурагт эвэртэй морь унасан хүнийг дүрсэлсэн байна (Цэвээндорж, 2004: 34-37) (Зураг 7).



Зураг 6. Эвэртэй дуулгат (?) баатар  
(Цэвээндорж нар. 2004: 41)



Зураг 7. Эвэртэй морьтон  
(Цэвээндорж нар. 2004: 43)

Эвэрт амьтанг тотемчлон үзэх үзлээс гадна эвэрт баатар, эвэртэн ван, эвэртэн дайчид гэх мэт цол хэргэм зэргийн эвэр шүтлэгийн хэлбэр байдаг. Тухайлбал: “Хоу хань шу”-гийн мэдээгээр Хүннүд арван эвэртэн ван байсан. Эхний дөрвөн ванг “Дөрвөн эвэртэн ван”, дараах зургааг “Зургаан эвэртэн ван” гэнэ (Сүхбаатар, 2000: 59). Мөн Солонгост эвэртэй малгай өмссөн “Эвэрт ван” байжээ (Сумьяабаатар, 1975: 71-75). Японы самуурай нар дуулгандаа буга, үхрийн эвэр зүүдэг нь тухайн гэр бүлийн шүтлэгт амьтан байхаас гадна зөвхөн самуурай буюу вангийн хэргэм зэрэгтэй дүйцэхүйц эрх мэдэлтэй хүмүүс л эвэртэй малгай өмсдөг байсан бололтой.

Европод анх төмрийн эрин үед эвэрт дуулга нь ёслолын болон зан үйлийн зориулалтаар гарч ирсэн гэж үздэг. Ойролцоогоор МЭӨ 800 онд Данийн Zealand-аас анхны эвэрт дуулга, Английн Thames мөрний хөндийгөөс Ромын эзэнт гүрнээс өмнөх үед хамаарагдах хүрэл дуулгыг тус тус олджээ. Энэхүү дуулганы эвэр нь шулуун, конус хэлбэртэй байсан нь өмнөх олдворуудаас ялгаатай байна. Шведээс МЭ V зуунд холбогдох металаар хийсэн дуулга олдсон. Тус дуулгын эврийг хоёр

могой эсвэл хоёр лууг дүрсэлсэн байдалтай хийсэн байна. Дуулгат эвэр нь Viking-ний үед хамгийн ихээр тархсан гэж ихэнх судлаачид үздэг (Зураг 8, 9) ([http://en.wikipedia.org/wiki/Horned\\_helmet](http://en.wikipedia.org/wiki/Horned_helmet)).

XX зууны эхээр зураач Frithiof Osebery болон Gokstad дахь археологийн малталтын үр дүн дээр үндэслэн Viking-ний баатрыг эвэрт дуулга өмссөнөөр дүрсэлжээ ([www.bbc.co.uk/history/ancient/vikings/revial\\_04.html](http://www.bbc.co.uk/history/ancient/vikings/revial_04.html)).

Эвэр зүүх өөр нэгэн жишээ бол дархад бөө нарын ёс юм. Бөө, удганы малгайн нүүрэн талд цагаан утас, ювуугаар хүний нүүрний дүрс гаргаж, хоёр талд нь чихний дүрс гаргана. Хоёр чихний хоёр талд гурав, гурван хонгинуур уядаг, малгайн дээд ирмэгт 7-9 ширхэг бүргэдийн өд буруу талаар нь босгож хадан, хоёр талд нь буга, гөрөөсний эвэр зүүдэг (Бадамхатан, 2002: 203). Малгай дээр байгаа хүний дүрс нь Чингисийн үед бурханы шашинтай тэмцэлдэж байсан хойд зүгийн баатрынх бөгөөд эвэртэй луустай тэмцэлдэж дийлсний дурсгал болгож малгайн өдний хажуу талд эвэр хадах (Бадамхатан, 2002: 232) болжээ.



Зураг 8. Эвэртэй дуулга



Зураг 9. Viking-ний эвэрт дуулга

Монголын үлгэр домог, туульст гунан улаан баатар далан эвэртэй морьтойгоор (Монгол ардын домог үлгэрүүд, 1984: 59), мөн дөш хар мангас далан эвэртэй догшин хар морьтойгоор (Монгол ардын баатарлаг туульс, 1982: 87) дүрслэгдсэн байдаг нь сөрөг дүрийг бүтээж буй мангасын дүрийг тод томруунаар тодорхойлохоос гадна унасан морийг далан эвэртэйгээр дүрсэлсэн нь сүр хүчийг нь тодорхойлж буй нэгэн дүрслэл болдог.

Монголчууд хүүхдийн үсийг засахдаа хоёр туг үс тавьж бусдыг нь авдаг. Энэхүү хоёр салаа бүхий үсийг “Эвэр үс” хэмээн нэрийдэж, тухайн хөвгүүнийг эвэртэн амьтдын адилаар сүр жавхаатай, эрүүл энх өсөн бойжихын бэлгэдэл болгон үсийг нь засдаг байна.

Эрх мэдэл бүхий албан тушаалтан, дарга нарыг “Эвэртэнгүүд” хэмээн нэрийдэх нь тухайн хүний эрх мэдлийн цар хүрээ, зэрэг дэв, сүр хүчийг тодорхойлохуйц ойлголт болжээ.

Дээр дурдсан баримтуудаас нэгтгэн үзвэл ан амьтдын дотроос бусдаас ялгагдахуйц онцлог, сүр жавхаатай, гоо сайхны билгэ тэмдэг болох бугыг хайрлан хамгаалж, шүтэн биширсээр ирсэн уламжлал байжээ. Өөр нэгэн жишээ бол хүрэл

зэвсгийн үеийн дурсгал болох буган чулуун хөшөөнд бугыг бодит байдлаар болон загварчлан дүрсэлж ирсэн нь бугыг шүтэх тотемизмтэй холбоотой бололтой.

Булшнаас бугын эвэр гарч буйг бөөгийн шашны зан үйлийн үүднээс тайлбарлан бөө хүний оршуулга хэмээн үзэж болох ч тухайн хүнийг оршуулсан байдал нь бөө, удганыг хатаан занданшуулах болон ил тавин оршуулдаг (Далай, 1959: 40) ёс заншлаас өөр байгаа нь дээрх булшны тодорхойлтуудаас харагдаж байна.

Эвэрт ан амьтан, эвэр шүтлэг нь Монголчуудын дунд эртнээс өнөөг хүртэл уламжлагдан иржээ. Эвэр нь эрх мэдлийн бэлгэ тэмдэг, бусдад үзүүлэх сүр хүчний илэрхийлэл болж байсан нь эх сурвалжуудын мэдээ зангиас харагдаж байна.

### НОМ ЗҮЙ

- Анхбаяр Д.*, 2005. Буган чулуун хөшөөн дэх дүрслэлүүийн утга зүйн асуудалд. Түүх, археологи, угсаатны соёл. МУИС-ийн ЭШБ 12 (1), х.4-18.
- Бадамхатан С.*, 2002. Хөвсгөлийн дархад ястан. Эрдэм шинжилгээний бүтээлүүд-I. УБ.
- Баруун Монгол. Тамирын улаан хошуунд явуулсан хээрийн судалгааны тайлан*, 2006. УБ. МУИС-ийн Археологи-Антропологийн Тэнхим.
- Горбунов А.П., Самашев З.С., Северский Э.В.*, 2005. Сокровища мерзлых курганов казахского алтая (по материалам могильника берел). Алматы
- Далай Ч.*, 1959. Монголын бөөгийн мөргөлийн товч түүх. УБ.
- Ерөөл-Эрдэнэ Ч.*, 2004. Гол модны хүннү булшны судалгааны зарим үр дүн. Археологийн судлал Т.II (XXII). f. 8. т.76 - 110.
- Ерөөл-Эрдэнэ Ч.*, 2007. Хүннүчүүд Грек, Ромтой харилцаж байсан байж болзошгүй сонин таамаг гарч байгаа. Өдрийн сонин. 1273 (2725). 2007.11.16., т.17
- Монгол ардын баатарлаг туульс*, 1960. УБ.,
- Монгол ардын домог үлгэрүүд*, 1984. УБ.,
- Монгол ёс заншлын бага тайлбар толь*, 1990. УБ.,
- Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал*, 1999. УБ.,
- Монголын уламжлалт цээр ёсон. Монгол соёлын цуврал бичиг*, 1997. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо
- Төрбат Ц., Амартүвшин Ч., Эрдэнэбат У.*, 2003. Эгийн голын сав нутаг дахь археологийн дурсгалууд. УБ.
- Сүхбаатар Г.*, 2000. Монголчуудын эртний өвөг. УБ.,
- Сумьяабаатар Б.*, 1975. Монгол Солонгос туургатны угсаа гарал, хэлний хамаадал. УБ.
- Цэвээндорж Д., Кубарев В.Д., Очирхуяг Ц.*, 2004. Цагаан Салаа, Бага Ойгорын хадны зураг дахь адуу, тэмээний дүр. Археологийн судлал, Т.II (XXII). f. 5. УБ., т. 35-50
- Юнь Хёнвонь*, 2003. Морин толгойн хүннү булшны судалгаа. Монгол-Солонгосын анхдугаар симпоузмын илтгэлийн эмхтгэл, УБ., т. 121-137
- [http://en.wikipedia.org/wiki/Horned\\_helmet](http://en.wikipedia.org/wiki/Horned_helmet)
- [www.bbc.co.uk/history/ancient/vikings/revial\\_04.html](http://www.bbc.co.uk/history/ancient/vikings/revial_04.html)

### SUMMARY

B.Tsogzolmaa

### HORN WORSHIPPING TRADITION

Tradition of worshipping horn and horned animals among mongols is inherited since the dawn of history and is found depicted in rock arts and archaeological monuments. From historical sources it is known that horn was considered as a symbol of power and strength.